

**АГУУЛГА**

|  |           |
|--|-----------|
| <b>I. ОРШИЛ .....</b>  | <b>3</b>  |
| <b>II. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....</b>   | <b>4</b>  |
| II.1. Төслийн нэр.....   | 4         |
| II.2. Үйлдвэрлэх бүтээгдэхүүн .....  | 4         |
| II.3. Төслийн хүчин чадал, үргэлжлэх хугацаа .....   | 4         |
| II.4. Ашиглалтын технологи .....   | 4         |
| II.5. Бүтээгдэхүүн гаргалтын тооцоо .....  | 4         |
| II.6. Хүний нөөц .....   | 4         |
| II.7. Төслийн байршил.....   | 4         |
| II.8. Орд ашиглах тусгай зөвшөөрөл .....   | 5         |
| II.9. Ордын нөөцийн тооцоо.....  | 5         |
| II.10. Хүчин чадал.....  | 6         |
| II.11. Уурхайн ажлын горим .....   | 6         |
| II.12. Уурхайн нээлт, ашиглалтын систем .....  | 7         |
| II.13. Шимт хөрс хуулалт .....   | 7         |
| II.14. Угаан баяжуулах хэсэг.....  | 7         |
| II.15. Бүтээгдэхүүн гаргалтын төлөвлөгөө .....   | 7         |
| II.16. Ажиллах хүчний тооцоо .....   | 8         |
| II.17. Барилга байгууламж.....   | 8         |
| II.18. Төслийн эдийн засаг.....  | 12        |
| <b>III. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....</b>   | <b>14</b> |
| III.1. Байгаль орчны төлөв байдал.....   | 14        |
| <b>IV. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....</b>  | <b>15</b> |
| IV.1. Газрын гадаргад үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл .....  | 15        |
| IV.2. Агаарын чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл.....  | 15        |
| IV.3. Усан орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл .....  | 15        |
| IV.4. Хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл.....  | 15        |
| IV.5. Ургамлан нөмрөг .....  | 16        |
| IV.6. Амьтан.....  | 16        |
| IV.7. Нийгэм, эдийн засагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл .....   | 16        |
| <b>V. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ....</b>   | <b>17</b> |
| <b>VI. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....</b>   | <b>19</b> |
| <b>VII. ТЭРБУМ МОД ТАРИХ ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД.....</b>   | <b>23</b> |
| <b>VIII. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....</b>   | <b>26</b> |
| <b>IX. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....</b>   | <b>28</b> |
| <b>X. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..</b>  | <b>28</b> |
| <b>XI. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....</b>   | <b>28</b> |
| <b>XII. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....</b>  | <b>29</b> |
| <b>XIII. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ .....</b>   | <b>30</b> |
| <b>XIV. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....</b>                           | <b>31</b> |
| <b>XV. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....</b> | <b>33</b> |
| <b>XVI. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНҮҮДИЙН НИЙТ ЗАРДАЛ .....</b>                                      | <b>33</b> |
| <b>ДҮГНЭЛТ .....</b>   | <b>34</b> |
| <b>АШИГЛАСАН ХЭВЛЭЛИЙН ЖАГСААЛТ .....</b>  | <b>34</b> |

### ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

|   |    |
|---|----|
| Хүснэгт №- 1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл .....   | 4  |
| Хүснэгт №- 2 Талбайн цэгүүдийн солбицол .....   | 4  |
| Хүснэгт №- 3 Ашиглалтын нөөц, /Сорьц-880.0/ .....   | 5  |
| Хүснэгт №- 4 Ил уурхайн ажлын горим .....   | 6  |
| Хүснэгт №- 5 Ил уурхайн технологийн агуулга, бүрдэл .....   | 7  |
| Хүснэгт №- 6 Шимт хөрс хуулалт .....  | 7  |
| Хүснэгт №- 7 Удирдлага зохион байгуулалт .....  | 8  |
| Хүснэгт №- 8 Төслийн нийт ажилчдын тоо .....  | 8  |
| Хүснэгт №- 9 Барилга, байгууламжийн мэдээлэл .....  | 8  |
| Хүснэгт №- 10 Төслийн нийт цэвэр усны хэрэглээ .....  | 11 |
| Хүснэгт №- 11 Эдийн засгийн үр ашгийн үндсэн тооцооны задаргаа .....  | 12 |
| Хүснэгт №- 12 Агаарт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .....           | 17 |
| Хүснэгт №- 13 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .....       | 17 |
| Хүснэгт №- 14 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .....  | 18 |
| Хүснэгт №- 15. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ..... | 19 |
| Хүснэгт №- 16. Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайн солбилцолууд .....                                     | 20 |
| Хүснэгт №- 17. Биологи болон техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайн солбилцолууд .....                       | 21 |
| Хүснэгт №- 18. Тарьсан модны хашааны булангийн цэгийн солбилцолууд .....                                      | 23 |
| Хүснэгт №- 19. Дүйцүүлэн хамгаалах ажлаар нөхөн сэргээлт хийсэн талбайн солбилцолууд - 1 .....                | 26 |
| Хүснэгт №- 20. Дүйцүүлэн хамгаалах ажлаар нөхөн сэргээлт хийсэн талбайн солбилцолууд -2 .....                 | 27 |
| Хүснэгт №- 21 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт .....   | 28 |
| Хүснэгт №- 22 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт .....   | 29 |
| Хүснэгт №- 23 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт .....   | 30 |

### ЗУРГИЙН ЖАГСААЛТ

|   |    |
|---|----|
| Зураг № 1. Тусгай зөвшөөрлийн талбайн байршил .....                       | 5  |
| Зураг №2. Төслөл хэрэгжих газрын гадаад зам тээврийн зураг .....          | 10 |
| Зураг №3. Төсөл хэрэгжих газрын худгийн байршлын зураг .....              | 12 |
| Зураг № 4. Ус ашигласны төлбөр төлсөн баримт .....                        | 17 |
| Зураг № 5. Анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байршуулсан байдал .....        | 18 |
| Зураг № 6. 2024 онд нөхөн сэргээлт хийсэн талбайн байршлын зураг .....    | 19 |
| Зураг № 7. Техникийн нөхөн сэргээлт хийж байгаа үеийн зураг .....         | 20 |
| Зураг № 8. Биологийн нөхөн сэргээлтэд үр суулгаж байгаа үеийн зураг ..... | 21 |
| Зураг № 9. Тэрбум мод тарьсан газрын байршлын зураг .....                 | 23 |
| Зураг № 10. Мод суулгаж байгаа үеийн зураг .....                          | 24 |
| Зураг № 11. Мод суулгаж байгаа үеийн зураг .....                          | 25 |
| Зураг № 12. Галын багажны булан байршуулсан байдал .....                  | 29 |
| Зураг № 13. Гэрээний дагуу хог хаягдлын төлбөр төлсөн баримт .....        | 30 |
| Зураг № 14. Орчны хяналт шинжилгээний төлбөр төлсөн баримт .....          | 31 |
| Зураг № 15. Ажилчдын хувцас хэрэгсэл авсан байдал .....                   | 32 |

## I. ОРШИЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь алтны шороон ордын үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм, журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч “Шижиргоулд” ХХК-аас заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах ёстой баримт бичиг юм.

“Бор тал” нэртэй алтны шороон орд төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний үндсэн зорилго нь төслийг хэрэгжүүлэх явцад үүсэх бүхий л сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитоор төлөвлөх, улмаар энэхүү төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлэх юм.

### **БОМТ боловсруулах аргачлал:**

Тус төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчин, ногоон хөгжлийн яамны сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29 –ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийн хамт холбогдох байууллагад хүргүүлж байх зайлшгүй шаардлагатай болно.

## II. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хүснэгт №- 1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

|    |                         |             |   |
|----|-------------------------|-------------|---|
| 1  | Аж ахуйн нэгжийн нэр    |             | “Ноён тохой трейд” ХХК                          |
| 2  | Улсын бүртгэлийн дугаар |             | 9011048087                                      |
| 3  | Регистрийн дугаар       |             | 2774666   |
| 4  | Төслийн нэр             |             | “Бор тал” нэртэй алтны шороон орд ашиглах төсөл |
| 5  | Төслийн                 | Аймаг       | Төв аймаг                                       |
| 6  | байршил                 | Сум/        | Сэргэлэн сум                                    |
| 7  | Аж ахуйн                | Аймаг/Хот   | Улаанбаатар хот                                 |
| 8  | нэгжийн                 | Сум/Дүүрэг  | Баянгол дүүрэг                                  |
| 9  | хаяг                    | Баг/Хороо   | 10-р Хороолол                                   |
| 10 |                         | Гудамж/Байр | 11-09 тоот.                                     |
| 11 | Захирлын                | Нэр         | Ц. Ноостой                                      |
| 12 | мэдээлэл                | Утас        | 88115786  |

### II.1. Төслийн нэр

“Бор тал” нэртэй алтны шороон орд.

### II.2. Үйлдвэрлэх бүтээгдэхүүн

Алт

### II.3. Төслийн хүчин чадал, үргэлжлэх хугацаа

Бор талын алтны шороон ордын нөөцийг 2 жилийн хугацаанд, жилийн 105.0 мян.м<sup>3</sup> элс олборлон баяжуулах хүчин чадалтайгаар ажилласан.

### II.4. Ашиглалтын технологи

Гадаад болон дотоод овоолготой авто тээвэртэй ашиглалтын системээр ашиглана.

### II.5. Бүтээгдэхүүн гаргалтын тооцоо

Бор талын алтны шороон ордын нийт үйлдвэрлэлийн нөөц нь 0.07 гр/м<sup>3</sup> агуулга бүхий 169.45 мян.м<sup>3</sup> элс, шлихээр 11.46 кг буюу химийн цэврээр 10.11 кг алт байна. Үүнийг гравитацийн аргаар баяжуулж, 92.5 хувийн металл авалттайгаар төслийн нийт хугацаанд 10.6 кг шлихийн алт, химийн цэврээр 9.33 кг алт үйлдвэрлэнэ.

### II.6. Хүний нөөц


“Ноён тохой трейд” ХХК-ийн уурхайд эхний жилд 128 хоног, 2 дахь жилд 185 хоног ажиллана.

### II.7. Төслийн байршил

Улаанбаатар хотоос урагш 80 км, Төв аймгийн Зуунмод хотоос зүүн тийш 70 км, Сэргэлэн сумын төвөөс зүүн тийш 50 км, Налайх дүүргээс урагш 30 км, Баян сумаас 28 км-т байрладаг.

Хүснэгт №- 2 Талбайн цэгүүдийн солбицол

| № | Уртраг |       |        | Өргөрөг |       |        |
|---|--------|-------|--------|---------|-------|--------|
|   | Градус | Минут | Секунд | Градус  | Минут | Секунд |
| 1 | 107    | 21    | 38.44  | 47      | 29    | 41.72  |
| 2 | 107    | 21    | 38.33  | 47      | 30    | 37.79  |
| 3 | 107    | 21    | 12.33  | 47      | 30    | 37.79  |
| 4 | 107    | 21    | 12.45  | 47      | 29    | 41.72  |



Зураг № 1. Тусгай зөвшөөрлийн талбайн байршил

## II.8. Орд ашиглах тусгай зөвшөөрөл

Ашигт Малтмалын Газраас “Ноён тохой трейд” ХХК-нд Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших “Бор тал”-ын алтны шороон орд нэртэй газар 94.21 га талбай бүхий уурхайн эдэлбэрт ашигт малтмал ашиглах эрхийг олгож MV-007039 дугаар бүхий гэрчилгээг 2004 оны 03 сарын 08-ны өдөр олгосон байна.

## II.9. Ордын нөөцийн тооцоо

Бор талын алтны шороон алт агуулсан элсний ул нь газрын гадаргуугаас хамгийн ихдээ 1.8 метр гүнд оршиж байгаа бөгөөд Уурхай эцсийн хүрээ хязгаарыг тодорхойлон ашиглалтын нөөцийг тооцоход нийт нөөцөөс уурхайн хүрээ хязгаарт С зэрэглэлээр 122.72 мян.м<sup>3</sup> элс /10.11 кг алт хими цэвэр/ багтаж байна.

Хүснэгт №- 3 Ашиглалтын нөөц, /Сорьц-880.0/

| Блокний дугаар       | Блокний талбай        | Хөрсний зузаан | Элсний зузаан | Хөрс хуулалт          | Элсний нөөц           | Дундаж агуулга /шлх/ | Металлын нөөц /Шлх/ | Металлын нөөц /хими нөөц /кг/ | ЦЭВЭР/ |
|----------------------|-----------------------|----------------|---------------|-----------------------|-----------------------|----------------------|---------------------|-------------------------------|--------|
| Х.нэгж               | /мян.м <sup>2</sup> / | /м/            | /м/           | /мян.м <sup>3</sup> / | /мян.м <sup>3</sup> / | гр/м <sup>3</sup>    | /кг/                | /кг/                          |        |
| <b>Дээд давхарга</b> |                       |                |               |                       |                       |                      |                     |                               |        |
| С-1                  | 2.89                  | 0.80           | 0.40          | 2.31                  | 1.15                  | 0.100                | 0.12                | 0.10                          |        |
| С-2                  | 6.23                  | 0.60           | 0.30          | 3.91                  | 2.14                  | 0.095                | 0.20                | 0.18                          |        |
| С-3                  | 6.59                  | 0.80           | 0.30          | 4.94                  | 1.65                  | 0.136                | 0.22                | 0.20                          |        |

|                      |        |      |      |        |        |       |       |       |
|----------------------|--------|------|------|--------|--------|-------|-------|-------|
| C-4                  | 21.11  | 1.10 | 0.40 | 23.93  | 8.44   | 0.130 | 1.09  | 0.96  |
| C-5                  | 30.77  | 1.10 | 0.40 | 34.87  | 13.54  | 0.103 | 1.39  | 1.23  |
| C-6                  | 3.47   | 1.10 | 0.20 | 3.71   | 0.70   | 0.091 | 0.06  | 0.06  |
| C-7                  | 12.91  | 1.20 | 0.50 | 15.13  | 6.64   | 0.093 | 0.61  | 0.54  |
| C-8                  | 1.35   | 0.40 | 0.60 | 0.54   | 0.81   | 0.240 | 0.19  | 0.17  |
| C-9                  | 3.50   | 0.60 | 0.20 | 2.10   | 0.70   | 0.113 | 0.08  | 0.07  |
| C-10                 | 1.52   | 0.20 | 0.20 | 0.30   | 0.30   | 0.155 | 0.05  | 0.04  |
| C-11                 | 15.60  | 1.10 | 0.30 | 16.38  | 5.07   | 0.062 | 0.31  | 0.28  |
| C-12                 | 26.02  | 0.90 | 0.60 | 22.67  | 16.73  | 0.074 | 1.24  | 1.10  |
| C-13                 | 32.37  | 0.80 | 0.60 | 26.97  | 20.86  | 0.066 | 1.38  | 1.21  |
| C-14                 | 25.36  | 0.90 | 0.60 | 22.27  | 15.88  | 0.129 | 2.04  | 1.80  |
| C-15                 | 16.04  | 1.00 | 0.70 | 15.61  | 11.55  | 0.062 | 0.72  | 0.63  |
| C-16                 | 8.08   | 0.80 | 0.60 | 6.28   | 4.67   | 0.204 | 0.95  | 0.84  |
| C-17                 | 8.96   | 0.80 | 1.00 | 6.87   | 8.66   | 0.066 | 0.57  | 0.50  |
| C-18                 | 6.23   | 0.80 | 0.40 | 4.98   | 2.28   | 0.060 | 0.14  | 0.12  |
| Нийт В               | 0.00   | 0.00 | 0.00 | 0.00   | 0.00   | 0.00  | 0.00  | 0.00  |
| Нийт С               | 228.99 | 0.85 | 0.60 | 213.78 | 121.76 | 0.093 | 11.36 | 10.03 |
| Нийт (В+С)           | 228.99 | 0.85 | 0.60 | 213.78 | 121.76 | 0.093 | 11.36 | 10.03 |
| <b>Доод давхарга</b> |        |      |      |        |        |       |       |       |
| C-19                 | 0.56   | 0.80 | 0.40 | 0.44   | 0.22   | 0.150 | 0.03  | 0.02  |
| C-20                 | 1.84   | 0.90 | 0.40 | 1.66   | 0.74   | 0.098 | 0.07  | 0.06  |
| Нийт В               | 0.00   | 0.00 | 0.00 | 0.00   | 0.00   | 0.00  | 0.00  | 0.00  |
| Нийт С               | 2.40   | 0.85 | 0.60 | 2.10   | 0.96   | 0.104 | 0.10  | 0.08  |
| Нийт (В+С)           | 2.40   | 0.85 | 0.60 | 2.10   | 0.96   | 0.104 | 0.10  | 0.08  |
| Нийт В               | -      | -    | -    | -      | -      | -     | -     | -     |
| Нийт С               | 231.38 | 0.80 | 0.40 | 215.88 | 122.72 | 0.093 | 11.46 | 10.11 |
| Нийт (В+С)           | 231.38 | 0.80 | 0.40 | 215.88 | 122.72 | 0.093 | 11.46 | 10.11 |

## II.10. Хүчин чадал

Ил уурхайн улирал бүрийн олборлолт харилцан адилгүй байх ба эхний жилд 64.64 мян.м<sup>3</sup>, 2 дахь жилд 104.81 мян.м<sup>3</sup> элс олборлохоор төлөвлөсөн.

Ил уурхайн олборлолтыг төлөвлөсөн хүчин чадлаар тооцоход Бор талын алтны шороон ордын нөөцийг 2 жилийн хугацаанд олборлохоор байна.

## II.11. Уурхайн ажлын горим

“Ноён тохой трейд” ХХК нь Бор талын алтны шороон ордын хөрс хуулалт, олборлолтын ажлыг жилийн II-р улирлаас III-р улирал хүртэл хугацаанд явуулна. Ил уурхайн олборлолтыг төлөвлөсөн хүчин чадлаар тооцоход 2 жилийн хугацаанд олборлохоор байна.

*Хүснэгт №- 4 Ил уурхайн ажлын горим*

| № | Үзүүлэлт                   | Хэмжих нэгж | Хэмжээ |
|---|----------------------------|-------------|--------|
| 1 | Ээлжийн үргэлжлэх хугацаа  | цаг         | 12     |
| 2 | Бүтээлтэй ажиллах хугацаа  | цаг         | 10     |
| 3 | Хоног дахь ээлжийн тоо     | ээлж/хон    | 1      |
| 4 | Жилд ажиллах хоногийн тоо  | хоног/жил   | 77     |
| 5 | Жилд ажиллах ээлжийн тоо   | ээлж/жил    | 77     |
| 6 | Жилийн ажлын цагийн хэмжээ | цаг/жил     | 770    |
| 7 | Цаг ашиглалт               | %           | 83     |
| 8 | Жилд ажиллах бодит цаг     | цаг         | 639    |

## II.12. Уурхайн нээлт, ашиглалтын систем

Уурхайн С-2 блокоос эхлэн олборлолт явуулах бөгөөд замын ерөнхий схем нь уурхайн баруун хойд хажууг даган өгсөж 1564 м түвшин хүрнэ.

**Ашиглалтын технологи:** Бор талын алтны шороон ордын хөрсний зузаан нь таазны бохирдол хасаж тооцсоноор дунджаар 0.74 м байна. Иймд шимт хөрсийг 0.2 м зузаантайгаар хуулан овоолно.

Ордын алт агуулсан элс нь хэвтээ ойролцоогоор 8<sup>0</sup> уналтай, нөөцийн блокуудын өргөн жигд үргэлжилдэг тул ашиглалт явуулсан талбайд дотоод овоолго хийж ашиглах ба ордын ашиглалтанд ил аргаар авто тээвэртэй гадаад дотоод овоолготой ашиглалтын системийг ашиглаж байна.

Хүснэгт №- 5 Ил уурхайн технологийн агуулга, бүрдэл

| Технологи  | Үндсэн ажил  | Технологийн процессууд                               |
|--|--------------|--|
| Ил аргаар авто тээвэртэй, гадаад, дотоод овоолготой ашиглалтын технологи | Хөрс хуулалт | Экскавац   |
|  | Олборлолт    | Ухаж ачих<br>Тээвэрлэх<br>Овоолох (агуулахад хураах) |

## II.13. Шимт хөрс хуулалт

Шимт хөрсийг Т-170 маркийн бульдозероор түрж шимт хөрсний овоолгод овоолно. Шимт хөрсний овоолгыг 35<sup>0</sup> градусын налуутайгаар үерийн ус болон салхины нөлөө бага байх газар байгуулна. Шимт хөрсийг уурхайн талбайгаас 0.2 метр зузаантайгаар 46.28 мян.м<sup>3</sup> /сийрэгжээгүйгээр/ шимт хөрс хуулж овоолно.

Хүснэгт №- 6 Шимт хөрс хуулалт

| Ашиглалтын жилүүд | Шимт хөрс хуулалт, мян.м <sup>3</sup> |                |       |
|-------------------|---------------------------------------|----------------|-------|
|                   | Нуур орчмын талбай                    | Уурхайн талбай | Нийт  |
| 1 дэх жил         | 1.37                                  | 18.06          | 19.43 |
| 2 дахь жил        |                                       | 37.47          | 37.47 |
| Нийт              | 1.37                                  | 55.53          | 56.90 |

## II.14. Угаан баяжуулах хэсэг

Угаан ангилах төхөөрөмжийн хүрдэн шүүрийн доод ангиллын бүтээгдэхүүн шлюзийн баяжуулалт руу орно. Шлюзны баяжмалыг ээлжиндээ 1 удаа /8 цаг тутамд/ авах ба баяжмал хадгалах саванд цуглуулна. Цуглуулсан баяжмалыг баяжуулах ширээгээр гүйцээн баяжуулна. Баяжуулах ширээнээс шлихийн алт, завсрын бүтээгдэхүүн, хаягдал гэсэн 3 бүтээгдэхүүн гарна.

## II.15. Бүтээгдэхүүн гаргалтын төлөвлөгөө

“Бор тал” -ын алтны шороон ордын нийт үйлдвэрлэлийн нөөц нь 51.66 мян.м<sup>3</sup> элс, 1.12 гр/м<sup>3</sup> агуулгатай элсэн дэх алт нь 58.05 кг буюу химийн цэврээр 50.5 кг алт агуулсан элсний нөөцтэй. Үүнийг гравитацийн аргаар баяжуулж, 94.3 хувийн металл авалттайгаар төслийн нийт хугацаанд 54.74 кг шлихийн алт, химийн цэврээр 47.63 кг алт үйлдвэрлэнэ.

## II.16. Ажиллах хүчний тооцоо

Ажилчдын орон тоог төслийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай техник технологи, төслийн хүчин чадал, тоног төхөөрөмжийн тоо нэг бүрийг харгалзан тооцоо. Төслийн хүчин чадлыг бүрэн ашиглахад хангалттай тооны ажилчдыг тусгаж өгсөн бөгөөд уурхайн ажлын горим 1 ээлжээр ээлжийн үргэлжлэх хугацаа 8 цаг, угаан баяжуулах хэсгийн ажлын горим 1 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 8 цаг байна.

Хүснэгт №- 7 Удирдлага зохион байгуулалт

| Уулын хэсэг               | Угаан баяжуулах хэсэг | Засвар механикийн хэсэг    | Захиргаа, аж ахуй, үйлчилгээний хэсэг |
|---------------------------|-----------------------|----------------------------|---------------------------------------|
| Захирал, уурхайн дарга    | Баяжуулагч            | Механик-цахилгааны инженер | Нярав, нягтлан                        |
| ХАБЭА, БО-ны ажилтан      | Усан механикч         | Засварчин                  | Тогооч                                |
| Экскаваторын оператор     |                       |                            | Жолооч                                |
| Утгуурт ачигчийн оператор |                       |                            | Үйлчлэгч, туслах                      |
| Автосамосвалын жолооч     |                       |                            |                                       |
| Бульдозерын оператор      |                       |                            |                                       |

Хүснэгт №- 8 Төслийн нийт ажилчдын тоо

| № | Хэсэг нэгж                            | 1 дэх жил | 2 дахь жил |
|---|---------------------------------------|-----------|------------|
| 1 | Уулын хэсэг                           | 13        | 13         |
| 2 | Угаан баяжуулах хэсэг                 | 6         | 6          |
| 3 | Засвар механикийн хэсэг               | 4         | 4          |
| 4 | Захиргаа, аж ахуй, үйлчилгээний хэсэг | 7         | 7          |
| 5 | Нийт                                  | 30        | 30         |

## II.17. Барилга байгууламж

“Ноён тохой трейд” ХХК нь тусгай зөвшөөрлийн талбайд уурхайн захиргаа, засвар үйлчилгээний төв зэрэг барилга байгууламжуудыг байрлуулахаар тооцов.

Орд ашиглалтын хугацаа бага тул зөөж тээвэрлэхэд хялбар шийдлийг сонгосон болно.

Хүснэгт №- 9 Барилга, байгууламжийн мэдээлэл

| №                | Барилгын нэр                      | Х.нэгж         | Хэмжээ | Тайлбар                                     |
|------------------|-----------------------------------|----------------|--------|---|
| <i>Хотхон</i>    |                                   |                |        |   |
| 1                | Уурхайн удирдлагын байр           | м <sup>2</sup> | 20     | Зөөврийн сууц 1 ш                           |
| 2                | Ажилчдын сууц                     | м <sup>2</sup> | 28     | 40 тн контейнер-хаус 4 ш                    |
| 3                | Цайны газар                       | м <sup>2</sup> | 14     | 20 тн тохижуулсан контейнер 1 ш             |
| 4                | Халуун ус болон угаалга           | м <sup>2</sup> | 14     | 20 тн тохижуулсан контейнер 1 ш             |
| <i>Ил уурхай</i> |                                   |                |        |   |
| 5                | Засварын газар, сэлбэгийн агуулах | м <sup>2</sup> | 28     | 40 тн контейнер 1 ш                         |
| 6                | Засварын талбай                   | м <sup>2</sup> | 100    | Шимт хөрсийг хуулж, талбайг тэгшилсэн байна |
| 7                | Түлшний ёмкост                    | тн             | 15     | Шимт хөрсийг хуулж, талбайг тэгшилсэн байна |

### II.17.2. Уурхайн тосгон

**Ажилчдын сууц:** Уурхайн тосгон тусгай зөвшөөрлийн талбайд 14 м<sup>2</sup> талбай бүхий 4 ширхэг 20 тонны контейнерээс бүрдэнэ. Ажилчдын хотхоныг нийт 18 хүн, нөөц



тооцсоноор 21 хүн зэрэг байрлах хүчин чадалтай, шаардлагатай тавилга, эд хогшлоор тоноглогдсон байна. Ажилчдын сууцыг 40 тонны контейнерийг засч тохижуулан хүн амьдрах тав тухыг бүрдүүлсэн байна. 1 контейнер-хауст 6 хүн амьдрахаар тооцлоо.

**Хоолны газар:** Цайны газар нь ажилчдын сууцны нэгэн адил 20 тонны контейнерыг засаж тохижуулан хүн тав тухтай хооллох орчныг бүрдүүлсэн байна. 1 контейнер-хауст 1 удаадаа 15-20 хүн зэрэг хооллох бөгөөд 1 хүнд дунджаар 2.4 м<sup>2</sup> талбай ноогдож байна.

### **II.17.3. Холбооны байгууламж**

Уурхайн орчимд үүрэн телефоны G-Mobile, Mobicom, Unitel корпорацийн сүлжээ барьдаг. Уурхайн экскаватор, автосамосвал, бульдозер зэрэг үндсэн тоног төхөөрөмжийн операторууд, ээлжийн дарга нар богино долгионы радио холбоогоор хангагдана.

### **II.17.4. Түлшний агуулах**

Түлшний агуулахаас тоног төхөөрөмжүүдийг түлшээр хангана. Түлшний агуулах нь 10 хоногийн нөөц буюу 15000 литр түлш хадгалах багтаамжтай байна. Эдгээр нь тусдаа шахуурга болон шүүлтүүртэй байна. Түлшийг шүүж цэвэрлэсний дараа тоног төхөөрөмжүүдийг түлшээр цэнэглэнэ. Мөн түлш ачих, буулгах хэсэгт гал унтраах, аянга зайлуулагч хэрэгслүүд байрлана. Түлш асгарч хөрсийг бохирдуулахаас сэргийлж автомашин цэнэглэх талбайг хатуу хучилттайгаар хийж өгнө.

### **II.17.5. Засвар механикийн барилга байгууламж**

Уурхайн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг үйлдвэрийн талбайд байрлах засварын талбайд хийж гүйцэтгэнэ. Засварын талбайд дугуй засвар, гагнуур, компрессорын станц зэргийг эхний ээлжинд байгуулна.

### **II.17.6. Цахилгаан хангамж**

**Цахилгаан хангамжийн эх үүсвэр:** Бор талын алтны шороон ордын уурхай нь Төмөр замын Багахангай-Баянгийн хоорондох 6 кВ хүчдэлийн агаарын шугамын №205 тулгуураас салбарлуулан, 6 кВ хүчдэлийн агаарын холболт авч, ТМ-100/6 кВа-ын хүчин чадалтай трансформатораас цахилгаан эрчим хүчээр хангаж байна.

### **II.17.7. Аянгаас хамгаалах байгууламж**


Уурхайн шатах тослох материалын агуулах болон засварын талбайг аянгын хамгаалалтын төхөөрөмж, түүнийг ашиглах журмын дагуу шатах тослох материалын агуулах ба засварын талбай нь аянгын шууд цохилтоос хамгаалагдсан байна.

### **II.16.7. Зам харилцаа**

“Ноён тохой трейд” ХХК-ийн “Бор тал” нэртэй газрын алтны шороон орд төслийн уурхайн лицензийн талбайд үүрэн холбооны бүх операторын сүлжээг ашиглах бүрэн боломжтой. Тус уурхай нь төв замаас 25 км орчим зайд байрлана

Засгийн газрын 2018 оны 379-р тогтоол “Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж барих, ашиглах журам”-ын хүрээнд авто замын чиглэлийг тухайн бүс нутгийн газар зүйн онцлог, зэрлэг ан, амьтны тархац, нутагшилт, тэдгээрийн шилжилт хөдөлгөөнд

нөлөөлөх байдал, аж ахуй нэгжээс уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэх талаар гаргасан хүсэлт, урьд нь батлагдсан авто замын чиглэл, баригдсан авто болон бусад төрлийн замыг харгалзан тухайн авто замын нийт урт нь хамгийн бага байх зарчмыг баримтлан тогтооно.



Зураг №2. Төслөл хэрэгжих газрын гадаад зам тээврийн зураг

### II.17.8. Усан хангамж, усны хэрэглээ

Төслийн талбай нь Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт харъяалагдана. Ил уурхай нь шүүрлийн усгүй болно.

“Бор тал” -ын алтны шороон ордын усны хэрэглээг уурхайд гаргасан 4ш гүний худгаас хангана. Худгийн нийт ундарга 9.1 л/с байна.

Гүний худгийн солбилцол нь 107°21'27.06, 47°30'54'09

107°19'15'07, 47°30'56'07

107°19'21'31.1, 47°30'56'07

107°21'27'30, 47°30'58'83 байна.

Уурхайн усны хэрэглээг БОНХАЖ-ын сайдын тушаалаар батлагдсан 2015.07.30-ны өдрийн А/301 тоот “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны нормоор тооцсон.

Хүснэгт №- 10 Төслийн нийт цэвэр усны хэрэглээ

| №           | Үзүүлэлтүүд               | Хэмжих нэгж    | Нийт ашиглалтын жилд |
|-------------|---------------------------|----------------|----------------------|
| 1           | Унд ахуй                  | м <sup>3</sup> | 450.7                |
| 2           | Зам талбай                | м <sup>3</sup> | 1,393.6              |
| 3           | Технологи                 | м <sup>3</sup> | 203,340.0            |
| 4           | Тэрбум мод                | м <sup>3</sup> | 980.0                |
| 5           | Нөхөн сэргээлтийн усалгаа | м <sup>3</sup> | 50,896.0             |
| <b>Нийт</b> |                           |                | 257,060.3            |


Уурхайн хэрэгцээнд худгаас ашиглалтын хугацаанд нийт 257.0 мян.м<sup>3</sup> ус хэрэглэхээр байна. Ордыг ашиглахад шаардлагатай усны ундрагын хэмжээ 8.3 л/с байна. Гүний худгийн ундарга 9.1 л/с бөгөөд уурхайн усны хэрэгцээг хангаж байна.

Төслийн хүрээнд MNS BS 8515:2019 стандартын дагуу хур борооны усыг хуримтлуулан зам усалгаа болон технологийн усанд ашиглахыг зөвлөмжилж байна. Энэхүү нь айл өрх, худалдаа үйлчилгээ, нийтийн үйлчилгээний газруудын угаалга, ариун цэврийн өрөө, зүлэг усалгаа зэрэг чанарын хувьд ундны бус зориулалтаар ахуйн хэрэглээнд ашиглах системд хамаарна. Харин хүнс, хоол бэлтгэх болон боловсруулах, хүнсний сав суулга угаах зэрэг ундны зориулалт, мөн хувийн ариун цэврийн хэрэглээний шаардлагад хамаарахгүй болно.

Тус стандартад борооны усыг гал түймэр унтраах, усалгааны зориулалтаар худалдан борлуулах тухай тусгайлсан зөвлөмж тусгаагүй боловч эдгээр хэрэглээг мөн үгүйсгээгүй болно. Энэ стандарт үерийн усны хяналтын систем сурилуулсан хувийн болон нийтийн хэрэглээний системд хамаарна. Борооны ус цуглуулах сав ашиглахад хамаарахгүй. Мөн уг стандартаар тусгай зориулалтын системийн бүрэлдэхүүн хэсгийн загварыг тогтоохгүй (заахгүй) бөгөөд шинээр баригдах болон өргөтгөх, шинэчлэн засварлах барилгад ашиглаж болно. Энэхүү стандарт саарал усыг дахин ашиглах системд MNS BS 8525-1:2015 хамаарахгүй болно.

### **Ус ашиглах төлбөр**

“Ноён тохой трейд” ХХК нь “Бор тал”-ын алтны шороон ордод тухайн жилийн ус ашиглуулах дүгнэлтийг “Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргаа”-тай байгуулах шаардлагатай.



Зураг №3. Төсөл хэрэгжих газрын худгийн байршилны зураг

Тухайн нутагт дэвсгэрт газар доорх усны түвшин жигд биш тул усны судалгаа гүйцэтгэж хамгийн боломжтой газарт худаг гаргуулсан. Энэ нь MV-007039 тоот тусгай зөвшөөрлийн талбайгаас гадна байрлах тул Сэргэлэн сумын тамгын газартай худаг байрлах газрын гэрээ байгуулж ажиллахыг зөвлөв.

Мөн багийн ИНХ-ын хүрээнд уурхайн үйл ажиллагаа бүрэн дууссаны дараа нөлөөллийн бүсэд байрлах тухайн нутгийн харъяат нэг айлд өөрийн эзэмшлийн 1 худгийг иж бүрдлээр нь хүлээлгэж өгнө.

## II.18. Төслийн эдийн засаг

Хүснэгт №- 11 Эдийн засгийн үр ашгийн үндсэн тооцооны задаргаа

| Үзүүлэлт                           | Х/нэгж                         | Үндэслэл  | АХО | 1 дэх жил | 2 дахь жил | Нийт   |
|------------------------------------|--------------------------------|-----------|-----|-----------|------------|--------|
| Уулын цул                          | мян.м <sup>3</sup>             |           |     | 123.67    | 247.34     | 371.01 |
| Элс олборлолт                      | мян.м <sup>3</sup>             |           |     | 64.64     | 104.81     | 169.45 |
| Хөрс хуулалт                       | мян.м <sup>3</sup>             |           |     | 59.03     | 142.53     | 201.56 |
| Хөрс хуулалтын коэффициент         | м <sup>3</sup> /м <sup>3</sup> |           |     | 0.91      | 1.36       | 1.19   |
| Угаан баяжуулах элс (цулаар)       | мян.м <sup>3</sup>             |           |     | 64.64     | 104.81     | 169.45 |
| Элсэн дэх алтны агуулга            | мг/м <sup>3</sup>              |           |     | 0.07      | 0.06       | 0.14   |
| Элсэн дэх алт /шлихээр/            | кг                             |           |     | 4.84      | 6.63       | 11.46  |
| Алт авалт                          | %                              |           |     | 92.50     | 92.50      | 92.50  |
| Алт гаргалт /шлихээр/              | кг                             |           |     | 4.47      | 6.13       | 10.60  |
| Алт гаргалт /химийн цэврээр/       | кг                             |           |     | 3.94      | 5.40       | 9.33   |
| Алтны үнэ                          | \$/унци                        | 1,801.57  |     |           |            |        |
| Алтны үнэ (сүүлийн 6 сарын дундаж) | төг/гр                         | 166,820.4 |     |           |            |        |

|  |         |          |          |          |         |          |
|--|---------|----------|----------|----------|---------|----------|
| Борлуулалтын орлого                    | сая.төг |          |          | 649.89   | 890.91  | 1,540.79 |
| Үйлдвэрлэл, үйл ажиллагааны зардал     |         |          |          |          |         |          |
| Уулын хэсгийн зардал                   | сая.төг |          |          | 141.06   | 229.19  | 370.24   |
| Баяжуулах хэсгийн зардал               | сая.төг |          |          | 190.17   | 297.11  | 487.28   |
| Засвар механикийн хэсэг                | сая.төг |          |          | 31.03    | 46.17   | 77.19    |
| Аж ахуй, үйлчилгээний хэсэг            | сая.төг |          |          | 49.93    | 72.02   | 121.95   |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл               | сая.төг |          |          | 52.16    | 57.95   | 110.11   |
| Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр  | сая.төг | 5.00%    |          | 32.49    | 44.55   | 77.04    |
| Нөхөн сэргээлт, хаалтын зардал         | сая.төг |          |          | 38.06    | 88.82   | 126.88   |
| Тусгай зөвшөөрлийн төлбөр              | сая.төг |          |          | 2.05     | 2.05    | 4.10     |
| Газрын төлбөр                          | сая.төг |          |          | 3.77     | 3.77    | 7.54     |
| АТӨЯХАТ болон агаарын бохирдлын төлбөр | сая.төг |          |          | 0.71     | 0.71    | 1.42     |
| Орон нутгийг дэмжих сангийн зардал     | сая.төг |          |          | 15.0     | 15.0    | 30.00    |
| Нийт зардал                            | сая.төг |          |          | 556.42   | 857.32  | 1,413.74 |
| 1 гр алтны бүрэн өөрийн өртөг          | төг/гр  |          |          | 141,342  | 158,859 | 151,552  |
| Татварын өмнөх ашиг                    | сая.төг |          |          | 93.46    | 33.59   | 127.05   |
| ААНОАТ                                 | сая.төг | 10%; 25% |          | 10.85    | 4.86    | 15.70    |
| Цэвэр ашиг                             | сая.төг |          |          | 82.62    | 28.73   | 111.34   |
| ҮАМУ                                   | сая.төг |          |          | 134.77   | 86.68   | 221.45   |
| Хөрөнгө оруулалт                       |         |          |          |          |         |          |
| Барилга байгууламж                     | сая.төг |          | (160.00) |          |         | (160.00) |
| Машин тоног төхөөрөмж                  | сая.төг |          | (253.80) |          |         | (253.80) |
| Тавилга эд хогшил                      | сая.төг |          | (6.80)   |          |         | (6.80)   |
| Дэд бүтэц                              | сая.төг |          | (40.00)  |          |         | (40.00)  |
| Балансын үлдэх өртөг                   | сая.төг |          |          |          | 344.70  | 344.70   |
| Нийт хөрөнгө оруулалт                  | сая.төг |          | (460.60) | 0.00     | 344.70  | (115.90) |
| ХОДМУ                                  | сая.төг |          | (460.60) | 134.77   | 431.38  | 105.55   |
| ХОДМУ (өссөн дүнгээр)                  | сая.төг |          | (460.60) | (325.83) | 105.55  |          |
| Өнөөгийн цэвэр үнэ, цэнэ (NPV, @8%)    | сая.төг | 34.03    |          |          |         |          |
| Өгөөжийн дотоод норм, IRR жилд         | %       | 22%      |          |          |         |          |
| Хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа       | жил     | 1.2      |          |          |         |          |

### III. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

#### III.1. Байгаль орчны төлөв байдал

**Газарзүйн нөхцөл:** Төв аймгийн Сэргэлэн сум нь Монгол Улсын хөгжлийн бүсчлэлээр төвийн бүсэд багтаж физик газарзүйн бүсчлэлээр Хангай Хэнтийн уулархаг мужид хамаарна. Сэргэлэн сумын газар нутгийн хэмжээ 74000м<sup>2</sup> хавтгай дөрвөлжин талбайтай. Хэнтийн нурууны баруун урд шувтрагын нам өндөртэй бөмбөгөр оройтой уулсын дунд засаг захиргааны хувьд хойд талаараа Эрдэнэ сумтай зүүн урд талаараа Баян сумтай урд талаараа Баянцагаан сумтай баруун талаараа Алтанбулаг зэрэг сумтай хиллэн оршино.

**Уур амьсгал:** Агаарын температурын сарын дундаж нь 1 дүгээр сард -17.2<sup>0</sup>С, 7 дугаар сард 15.9<sup>0</sup>С хүрч байна.

Төв аймгийн агаарын харьцангуй чийгшил дунджаар 840 гПа байдаг. Агаарын чийгшил нь даралт, температураас хамаарч өөрчлөгдөх ба өвөл 845.5 гПа, зун 838.7-842.7 гПа байдаг байна. Төв аймаг орчимд салхины дундаж хурд 4.6-5 м/сек байдаг. Улирлын байдлаар авч үзвэл, салхины хурд хаврын улиралд 4.2-4.6 м/сек, өвлийн улиралд 3.7 м/сек, бусад улиралд 2.9-5 м/сек тус тус байдаг байна. Хур тунадасны олон жилийн дундаж хэмжээ 232.1 мм бөгөөд түүний 90% нь дулааны улиралд буюу 4-9 дүгээр сард ордог байна. Төслийн талбайд жилийн дундаж харьцангуй чийгшил 37-72% хүрч хамгийн хуурай 8-р сард 72% байна.

**Усан хангамж:** Төслийн талбай нь Хойд мөсөн далайн ай савын бөгөөд түр зуурын элбэг тэжээлтэй, Хэнтийн дэд мужийн Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт харъяалагдана.

Төслийн талбайд гадаргын ус байхгүй байна. Төслийн талбайд өөрийн эзэмшлийн 4 гүний худагтай бөгөөд нийт усны хэрэглээгээ хангаж ажиллана.

**Хөрс, ургамал:** Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт орших “Бор тал” нэртэй алтны шороон орд нь газрын гадаргын хувьд Орхон-Сэлэнгийн бэсрэг уулын мужийн Туулын дэд мужид харъяалагдана. Төсөл хэрэгжих талбай нь хөрс газарзүйн мужлалтаар хөрс био-уур амьсгалын холимог бүсчлэл бүхий Хангайн мужийн өндрийн бүсчлэлийн хэв шинж бүхий өмнөд Хэнтийн 52-р тойрогт багтана.

Тухайн бүс нутаг нь ургамал газарзүйн мужлалын хувьд Евроазийн тал хээрийн мужид хамаарна. Монгол орны хээрийн бүс нутгийг илтгэх Хялганат хээр тохиолдоно.

**Амьтны аймаг:** Төсөл хэрэгжиж буй нутаг нь газарзүйн мужлалаар Дундад Халхын тойрогт тал хээрийн бүсэд хамаарна. Тус уурхайд өмнө нь олборлолт явуулж байсан учраас амьтад үргэн дайжсан байна.

Тус суманд амьтны аймгаас нийтлэг буюу зөвхөн тал хээрийн нөхцөлд дасан зохицсон амьтад тохиолдоно. Үүнд: туулай хэлбэртнээс бор туулай, огодой, мэрэгчдээс үлийн цагаан оготоно, махан идэштнээс саарал чоно, хярс, үнэг, шувуудаас шоорон эвэрт болжмор, монгол болжмор, шилийн сар, хөхтөн амьтнаас цагаан зээр зэрэг амьтад элбэг таардаг. Энэхүү бүс нутагт тохиолдох 6 баг, 17 овог, 40 төрөлд хамаарах 54 зүйл хөхтөн амьтан байдаг.

**Нийгэм, эдийн засаг:** Засаг захиргааны төвүүд нь Улаанбаатар хоттой засмал болон шороон замаар холбогдсон. Утсан харилцаа сайн хөгжсөн. Өндөр хүчдэлийн шугам, төмөр замтай. Ордын орчим гадаргын ус байхгүй, хур тунадас ихтэй үед зарим хөндийд үерийн ус түрж урсаж байдаг. Нийгэм эдийн засгийн хувьд тус сум нийт 2067 хүн амтай, хүн амын нягтаршил 0.5, өрхийн тоо 815 байна.

#### **IV. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ**

##### **IV.1. Газрын гадаргад үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл**

Уурхайд ачих, зөөж тээвэрлэх, боловсруулах тоног төхөөрөмж болон бусад машин механизмуудад урсгал засвар, техникийн үйлчилгээ хийх, төрөл бүрийн материал, сэлбэг хэрэгсэл, шингэн түлш, тос хүлээн авах, хадгалах, түгээх зориулалттайгаар засварын жижиг хэсэг ажиллана. Эдгээр үйл ажиллагааны явцад алтны шороон ордын газрын гадарга, хэвлий нь техникийн болон хүний хүчин зүйлийн нөлөөлөлд өртөхөөр байна,

##### **IV.2. Агаарын чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл**

- Агаарын бохирдол /уурхайн малталт, овоолгууд, тээвэрлэлтийн зам болон хөрс хуулалт зэрэг технологи ажиллагаанаас тоос дэгдэнэ/,
- Тээврийн хэрэгслийн шаталтат хөдөлгүүрээс ялгарах утаа тортогоос үүсэх бохирдлын нөлөө,
- Түр суурьшлын бүсэд хог хаягдал, шатах тослох материалын үнэр хүрээлэн буй орчинд тархана,
- Үйлдвэрлэлийн дотоод тээврийн замын нөлөөгөөр хөрсний бүтэц алдагдсанаас нарийн ширхэгтэй тоос агаарт дэгдэж тэр хэмжээгээр орчны газрын хөрс, ургамлан нөмрөгийг доройтолд оруулах.

##### **IV.3. Усан орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл**

- Төслөөс гадаргын усанд үзүүлэх нөлөөлөл байхгүй байна,
- Төслийн технологийн хэрэгцээнд хэрэглэх усыг газрын доорх усаас авч ашиглах учир гүний усны нөөцөд тодорхой хэмжээний хомсдол үүсэх,
- Төслийн үйл ажиллагаанаас ахуйн болон үйлдвэрийн хог хаягдал уурхайн орчинд тархаснаас хөрсийг бохирдуулснаас гүний усыг бохирдуулах,
- Тунаах нуурын далангийн суурийн бат бөх байдал, далан сэтэрч болзошгүй.

##### **IV.4. Хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл**

- Хөрсний элэгдэл, эвдрэл, үржил шимийн доройтол эрчимжинэ,
- Уурхайн дотоод тээврээр хөрс, ургамал талхлагдана,

- Уурхайд олон салаа шороон зам үүссэнээс хөрсний элэгдэл эвдрэл үүсэх,
- Шатах тослох материалын ашиглалт, хадгалалтаас үүдэлтэй хөрсний бохирдол хязгаарлагдмал орчинд үүснэ,
- Түр суурьшлаас эх үүсвэртэй хог хаягдлаар хөрс бохирдох,
- Тунгаах нуурын шаланд тунасан лаг орчныг хөрсийг бохирдуулах.

#### **IV.5. Ургамлан нөмрөг**

- “Бор тал” -ын алтны шороон ордын үйл ажиллагаа явагдаад олон жил болж байгаа учир олон салаа зам гаргах, ус цуглуулах зорилгоор татсан шуудуу, газрын эвдрэлээс шалтгаалсан доройтол олборлох үйл ажиллагаа явагдсан хэсгээр байна. Цаашид ашиглалтын талбай нэмэгдэхийн хирээр ургамалд үзүүлэх сөрөг нөлөөний цар хүрээ тэлэх боловч нөлөөллийн эрчим өсөхгүй,
- Уулын ажлын үед тээвэрлэлт, түр зам ашиглалт, орчны газар ашиглалт, тоосжилтоос ургамлын ургах орчин доройтох.

#### **IV.6. Амьтан**

- Төслийн үйл ажиллагаа, машин техник, тоног төхөөрөмжийн дуу чимээ, хөдөлгөөнөөс амьтад дайжин амьдрах орчин өөрчлөгдөх,
- Уурхайн ухсан нүх суваг, шуудуу руу мал амьтан уурхайн талбай руу унаж, бэртэх аюултай.

#### **IV.7. Нийгэм, эдийн засагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл**

- Төслийн нөлөөллийн бүсэд төвлөрсөн суурьшил байхгүй,
- Төслийн үйл ажиллагааны үед орон нутагт түр ажлын байр бий болно,
- Орон нутгаас нийлүүлэх боломжтой хүнсний хангамж, ахуйн хангамж, түлш шатахуун нийлүүлэлт зэрэг материаллаг эрэлт үүснэ,
- Улс орны төсөвт мөнгөн хуримтлал бий болгоно,
- Мөн үйл ажиллагааны явцад техникийн бүрэн бүтэн байдал алдагдах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаагүйгээс эсвэл гэнэтийн аюул осол гарснаас улбаалан ажилчдын эрүүл мэнд, амь нас эрсдэх зэрэг нийгэм эдийн засгийн олон сөрөг нөлөөлөл үүсэх магадлалтай.



## V. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Агаарын чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл:

- Ил уурхайн олборлолтын үед гарах тоосжилт,
- Тээвэрлэлтийн үеэс үүсэх тоосжилт,
- Уурхайн олборлолт, газар шорооны ажлаас үүсэх тоосжилт,
- Тээвэрлэлтэнд явж буй машинуудаас ялгарах хорт бодисуудаар орчны агаар бохирдох.

Хүснэгт №- 12 Агаарт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ  | Биелэлт   | Зардал /Төгрөг/          |
|---|--|---|--------------------------|
| 1 | Уурхайн олборлолтын үе шатанд тоосжилт ихээр үүсэх үед услагаа хийх, салхи ихтэй үед тоос багасгах арга хэмжээ авах  | Олборлолтын үед уурхайн замд хуурайшилт ихтэй үед болон шаардлагатай үе тухай бүрт нь усалгаа хийж байсан | Үйл ажиллагааны зардлаар |
| 2 | Хүнд механизмын хөдөлгүүрийн тохиргоо, үйлчилгээг тогтмол байлгах, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах арга хэмжээ авах | Хүнд механизмын тохиргоо үйлчилгээг тогтмол хийлгэсэн. /Төлбөрийн баримтыг хавсаргав/                     | Үйл ажиллагааны зардлаар |

Усан орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл:

- Усны нөөц хомсдох, багасах,
- Шатах тослох материалыг алдсанаар газрын доорх ус бохирдох.

Хүснэгт №- 13 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ                     | Биелэлт  | Зардал /Төгрөг/                        |
|---|---|--|--|
| 1 | Ус ашигласны төлбөрийг цаг тухай бүрт төлөх | Ус ашигласны төлбөрийг тухай бүрт төлсөн. /Баримтын хавсралтад давхар хавсаргав/ | Тоолуурын заалтаар нэхэмжилсэний дагуу |
|   | Нийт  |  | 22,165,479                             |

Системийн өндөр System Date: 2024-10-30

| ДТ | IBAN/Дансны/Картын дүгээр<br>IBAN/Account/Card number   | Нэр/Name  | Дүн/Amount       | Хангалт/Type |
|----|---|---|------------------|--------------|
|    | 9030239834  | НОЁН ЦЭРЭВ НООСТОЙ  | 9,449,874.00 MNT | 1.00         |
| КХ | Банком дугаар/Branch No<br>MORFILMNB<br>IBAN/Дансны/Картын дүгээр<br>IBAN/Account/Card Number<br>100140000944 | Банком нэр/Bank Name<br>ТӨРГӨМН САН<br>Нэр/Name<br>Тө.Ус ашигласны төлбөр | 9,449,874.00 MNT | 1.00         |

Гүйцэтгэлийн утга/Transaction Note: 3-Р ТООЛУУР УС АШИГЛАСНЫ ТӨЛБӨР

Системийн өндөр System Date: 2024-10-30

| ДТ | IBAN/Дансны/Картын дүгээр<br>IBAN/Account/Card number   | Нэр/Name  | Дүн/Amount       | Хангалт/Type |
|----|---|---|------------------|--------------|
|    | 9030239834  | НОЁН ЦЭРЭВ НООСТОЙ  | 5,254,074.00 MNT | 1.00         |
| КХ | Банком дугаар/Branch No<br>MORFILMNB<br>IBAN/Дансны/Картын дүгээр<br>IBAN/Account/Card Number<br>100140000944 | Банком нэр/Bank Name<br>ТӨРГӨМН САН<br>Нэр/Name<br>Тө.Ус ашигласны төлбөр | 5,254,074.00 MNT | 1.00         |

Гүйцэтгэлийн утга/Transaction Note: 3-Р ТООЛУУР УС АШИГЛАСНЫ ТӨЛБӨР

Системийн өндөр System Date: 2024-10-30

| ДТ | IBAN/Дансны/Картын дүгээр<br>IBAN/Account/Card number   | Нэр/Name  | Дүн/Amount       | Хангалт/Type |
|----|---|---|------------------|--------------|
|    | 9030239834  | НОЁН ЦЭРЭВ НООСТОЙ  | 7,461,531.00 MNT | 1.00         |
| КХ | Банком дугаар/Branch No<br>MORFILMNB<br>IBAN/Дансны/Картын дүгээр<br>IBAN/Account/Card Number<br>100140000944 | Банком нэр/Bank Name<br>ТӨРГӨМН САН<br>Нэр/Name<br>Тө.Ус ашигласны төлбөр | 7,461,531.00 MNT | 1.00         |

Гүйцэтгэлийн утга/Transaction Note: 3-Р ТООЛУУР УС АШИГЛАСНЫ ТӨЛБӨР

ЛАЦ ЛОМБО ТАВЬСАН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

Дугаар 11

Байгууллагын нэр: Бортоллын сум СДТТ

Лац ломбо тавьсан огноо, цаг, минут: 2024.05.28

Байгууллага аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтны нэр:  
Нөён нэгжийн үйлдвэр ХХК-н  
Уурхайн хэлтэс

4. “Ноён тохой трейд” ХХК нь 2019 онд 8 хайгуулын шугамын дагуу (Ш-3, 2, 0, 02, 04, 06, 08, 09) 200-100х10-20м торын нягтралтай, 1.0-3.0м гүнтэй, 100 ширхэг шурф буюу 222.7 тууш метр нэвтрэлтийн ажлыг эксковатораар хийж, сорьцлолтыг гар аргаар гүйцэтгэжээ. Шурфын хөндлөн огтлол 1.25х4,0м, сорьцын ховилын хэмжээ 0.5х0.4х0.2м, шурфын сорьцлолтыг 0,2м ахицаар гүйцэтгэж, нийт 1106 шир сорьц авч, угааж, боловсруулснаас алт илэрсэн 392ш дээжинд “ХРГГ” ХХК-иар үлээлт жигнэлтийн ажлыг гүйцэтгүүлжээ. Нийт 94.21 га талбайд 1:2000-ны масштабын байрзүйн зураг, шурф холболтын ажлыг “Ообоо” ХХК-иар, археологийн судалгааны ажлыг ШУТИС-ийн БУХС-ийн Хүмүүнлэгийн ухааны салбар, палеонтологийн судалгааг ШУТИС-ийн ГУУС-ийн Стратиграфи-палеонтологийн судалгааны төвөөр гүйцэтгүүлсэн байна.

5. Тус талбай нь геологи структурын хувьд Жанчивлангийн хүдрийн зангилгаанд, Монгол-Өвөр Байгалийн атираат системийн Хэнтийн блокт байрлах ба Үнэгт формацийн дээд протерозой-доод кембрийн үеийн хувирмал метаморфлог чулуулаг, кайнозойн тунамал чулуулгаас тогтсон байна.

Бор талын шороон ордын үндсэн хөндий 400-500м өргөн, нийт урт 10км, үүнээс хөндийн дунд талын 1900м хэсэг ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хамрагддаг. Налуу нь дээд хэсэгт 6-7<sup>0</sup>, доод хэсэгт 4-5<sup>0</sup>. Алтны хуримтлал дээд дөрөвдөгч-орчин үеийн /Q<sub>3-4</sub>/ настай делюви, пролювийн гаралтай хайрга, хайрганцар, дайрга, бүхий элсэрхэг, шаварлаг хурдсанд тогтсон.


**Дээд давхаргын дундаж үзүүлэлт:** Хөрс хуулалт 0.8м, элсний зузаан 0.5м, дундаж агуулга 93 мг/м<sup>3</sup>, хөрсний хэмжээ 213,8 мян.м<sup>3</sup>, элсний хэмжээ 121,8 мян.м<sup>3</sup>, алтны хэмжээ шлихээр 11,36кг, химийн цэврээр 10,03кг.

**Доод давхаргын дундаж үзүүлэлт:** Хөрс хуулалт 0.9м, элсний зузаан 0.4м, дундаж агуулга 110 мг/м<sup>3</sup>, хөрсний хэмжээ 2.1 мян.м<sup>3</sup>, элсний хэмжээ 1.0 мян.м<sup>3</sup>, алтны хэмжээ шлихээр 0.1кг химийн цэврээр 0.08 кг байна.

6. Алт агуулсан хурдасны найрлага, технологи шинж чанарыг судлах зорилгоор 04 дүгээр шугамын 38 дугаар шурфээс 580 кг, 04 дүгээр шугамын 34 дүгээр шурфээс 690 кг дээжийг ховилон аргаар авч, “Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын Технологи туршилт, эрдэс судлалын тасаг, ШУА-ийн ХХТХ-д технологийн туршилт хийлгэж, элсний угаагдах шинж чанар, технологийн схемийг боловсруулж, металл авалтыг тодорхойлсон байна. Технологийн туршилтаар скруббер-бутарт шлюз (85.5%) болон гүйцээн баяжуулалтанд сэгсрэх ширээг ашиглан баяжуулахад 95.2%-ын металл авалттай гэж тогтоосон. Нийт алтны 88.2% нь жижиг тоосонцор (0,5мм+0,063 мм) мөхлөгүүд эзэлж байна. Сорьц 880 гэж тогтоогджээ.

7. Зохиогчид ордын нөөцийн тооцоог гүйцэтгэхдээ дараах жишиг үзүүлэлтүүдийг баримталжээ. Үүнд:

- Давхаргын дээд, доод хилийг малталтанд ялгах захын сорьцын агуулга 30мг/м<sup>3</sup>
- Нөөцийн хүрээллийн захын малталтын хамгийн бага агуулга 48мг/м<sup>3</sup>
- Нөөцийн хэсэгшилийн үйлдвэрлэлийн хамгийн бага агуулга 50мг/м<sup>3</sup>



|  |      |
|--|------|
| - Ашигт давхаргын хамгийн бага зузаан                      | 0,2м |
| - Ашигт давхаргын доторхи хоосон хэсгийн хамгийн их зузаан | 0,6м |
| - Хэсэгшил дэх алттай давхаргын хамгийн бага өргөн         | 20м  |

8. Зохиогчид ордыг 3-р бүлгийн ордод хамааруулж, ордын нөөцийн тооцоог зүсэлтийн арга болон блокийн аргаар тооцон, зөрүү нь 8,4% байсан тул зүсэлтийн аргаар тооцсон үр дүнг авч, дээд давхаргын 18 хэсэгшил, доод давхаргын 2 хэсэгшилд боломжтой (С) зэрэглэлээр шлихээр 11.46кг, химийн цэврээр 10.11кг-аар тооцоолжээ.

Шинжээч дээрх нөөцийн тооцоонд хяналтын тооцоо хийж, ордын нөөцийг зохиогчдийн тооцоолсон хувилбараар хүлээж авахыг санал болгосон ба ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцэж зөвлөлийн гишүүдийн олонхийн саналаар нөөцийг шинжээчийн санал болгосоноор зохиогчийн тооцоолсон хувилбараар хүлээн авч, ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэх нь зүйтэй гэж үзэв.

9. Тус талбайн 80%-д орчин үеийн аллювийн сэвсгэр хурдас тархсан ба хурдасын зузаан нь 1.2-2.6м, газар доорхи болон гадаргын ус илрээгүй. 1994-1995 онд ашиглалтын талбайд хайгуулын 4-р шугамын дагуу өрөмдсөн цооногуудад 2-4м зузаан неогены шаварлаг хурдасын үе тогтоогдсон боловч уст үе илрээгүй. Дээд протерзой-доод кембрийн хурдаст ашиглалтын талбайн хойд гадна талд 0.4-3.5 км зайтай 80-92.0 м гүнтэй 4 худагтай, худгуудын ус нь ан цавархаг, өгөршилд орсон занар дотор 8.0-60.0 м-т илэрсэн. Ундарга нь 0.9-5.0 л/сек гэж тогтоогдсон. Баяжуулалтын талбайн хажууд 30мх30мх2м хэмжээтэй усан сан байгуулж, усыг дахин ашиглах журмаар ажилладаг ба 2-3 хоноод худгаас нуураа сэлбэдэг байна.


10. Урьдчилсан эдийн засгийн тооцоогоор нийтдээ 206.09 мян.м<sup>3</sup> хөрс хуулж, 145.94 мян.м<sup>3</sup> элс олборлон угааж, ордыг 2 жилийн хугацаанд ашиглах ба жилийн цэвэр бодит ашиг 201.5 сая.төг, төсөвт төлөх татвар 58.2 сая.төг гэж тооцжээ.

11. Цаашид ордын нөөц багатай тул эдийн засгийн хувьд эрсдэлтэй болохыг анхаарч эдийн засгийн тооцоог үндэслэлтэй боловсруулах, олборлолтын үед хяналтын ажил хийж баталгаажуулж ажиллах, байгаль орчны үнэлгээнүүд болон орд газрыг ашиглах ТЭЗҮ-ийг эрх бүхий хуулийн этгээдээр хийлгэх, холбогдох хууль тогтоомж, ялангуяа “Ашигт малтмалын тухай” хууль түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан заавар журмуудыг мөрдөж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид анхааруулахаар тогтов.

*Нөөцийн тооцоонд хийсэн шинжээчийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаас Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3, 48.4, Газрын хэвлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, 45.3 дахь хэсгүүд болон энэ дүгнэлт, холбогдох хуулийн заалтуудыг тус тус үндэслэн дараах шийдвэр гаргахыг Үндэсний геологийн албаны даргад уламжлахаар шийдвэрлэв. Үүнд:*

Нэг. “Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших Бор талын алтны шороон ордын өмнөд хэсгийн 8-09 дүгээр хайгуулын шугам хооронд 2019 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүн, нөөцийн шинэчилсэн тооцооны тайлан” (Ордын нөөц 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар) дахь алтны нөөцийг боломжтой (С) зэрэглэлээр шлихээр 11.46кг, химийн цэврээр 10.11кг-аар энэхүү дүгнэлтийн хавсралт хүснэгт №1-ийн дагуу хүлээн авах.

Хоёр. Хуралдааны энэхүү дүгнэлтийн дагуу хүлээн авсан алтны нөөцийг ашигт





малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэхийг ҮГА-ны Гео-мэдээллийн төв (Ц.Минжинсор)-д зөвшөөрөх.

Гурав. Энэхүү дүгнэлтийн 11 дүгээр заалтыг цаашдын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг “Ноён тохой трейд” ХХК (Ц.Ноостой)-д анхааруулах.

Дөрөв. Хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, хээрийн судалгааны анхдагч баримт, тайлангийн бичвэрийн дискийн хамт ЭБМЗ-ийн хуралдааны энэхүү дүгнэлт, түүний дагуу гаргасан ҮГА-ны даргын шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан, Геологийн баримтын төв архивт хүлээлгэн өгөхийг “Ноён тохой трейд” ХХК (Ц.Ноостой)-д даалгах.

Тав. “Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших Бор талын алтны шороон ордын өмнөд хэсгийн 8-09 дүгээр хайгуулын шугам хооронд 2019 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүн, нөөцийн шинэчилсэн тооцооны тайлан” боловсруулалтыг Монгол Улсын мэргэшсэн геологич Ц.Тайванбаатар, геологич Ж.Баярсайхан, Ц.Ноостой нар, лабораторийн шинжилгээний үр дүнг “ХРГГ” ХХК, байр зүйн зураглалын ажлыг “Ообоо” ХХК, археологийн судалгааны ажлыг ШУТИС-ийн БУХС-ийн Хүмүүнлэгийн ухааны салбар, палеонтологийн судалгааг ШУТИС-ийн ГУУС-ийн Стратиграфи-палеонтологийн судалгааны төв тус тус хариуцах, тайлан, түүн дэх ордын нөөцийн тооцоонд гаргасан шинжээчийн дүгнэлтийг Монгол Улсын мэргэшсэн геологич Л.Өнөржав, хайгуулын ажлын үнэн бодит байдлыг “Ноён тохой трейд” ХХК тус тус хариуцах.

ТАНИЛЦСАН:

ЭБМЗ-ИЙН ДАРГА

Б.ЭЛБЭГЗАЯА

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭБМЗ-ИЙН САЛБАР

ХУРАЛДААНЫ ДАРГА

А.ДЭЛГЭРСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН:

НАРИЙН БИЧГИЙН

ДАРГА

Б.МӨНХ-ЭРДЭНЭ

ЭБМЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн хуралдааны  
 XI-15-1д -р дүгнэлтийн хавсралт

Бор талын алтны шороон ордын өмнөд хэсгийн 8-09 дүгээр хайгуулын шугам  
 хоорондох нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт  
 (Ордын нөөц 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар)  
 Тусгай зөвшөөрлийн дугаар MV-007039

Хүснэгт-1

| Блокын дугаар  | Зузаан, м   |            | Дундаж агуулга, мг/м <sup>3</sup> | Блокын талбай, мян.м <sup>2</sup> | Эзэлхүүн, мян.м <sup>3</sup> |               | Металлын нөөц, кг |              |
|----------------|-------------|------------|-----------------------------------|-----------------------------------|------------------------------|---------------|-------------------|--------------|
|                | Хөрс        | Элс        |                                   |                                   | Хөрс                         | Элс           | Шлих              | Цэвэр        |
| Дээд давхарга  |             |            |                                   |                                   |                              |               |                   |              |
| С-1            | 0.8         | 0.4        | 100                               | 2886                              | 2309                         | 1154          | 0.12              | 0.10         |
| С-2            | 0.6         | 0.3        | 95                                | 6227                              | 3914                         | 2135          | 0.20              | 0.18         |
| С-3            | 0.8         | 0.3        | 136                               | 6590                              | 4943                         | 1648          | 0.22              | 0.20         |
| С-4            | 1.1         | 0.4        | 130                               | 21110                             | 23925                        | 8444          | 1.09              | 0.96         |
| С-5            | 1.1         | 0.4        | 103                               | 30765                             | 34867                        | 13537         | 1.39              | 1.23         |
| С-6            | 1.1         | 0.2        | 91                                | 3473                              | 3705                         | 695           | 0.06              | 0.06         |
| С-7            | 1.2         | 0.5        | 93                                | 12913                             | 15127                        | 6641          | 0.61              | 0.54         |
| С-8            | 0.4         | 0.6        | 240                               | 1354                              | 542                          | 812           | 0.19              | 0.17         |
| С-9            | 0.6         | 0.2        | 113                               | 3497                              | 2098                         | 699           | 0.08              | 0.07         |
| С-10           | 0.2         | 0.2        | 155                               | 1519                              | 304                          | 304           | 0.05              | 0.04         |
| С-11           | 1.1         | 0.3        | 62                                | 15603                             | 16383                        | 5071          | 0.31              | 0.28         |
| С-12           | 0.9         | 0.6        | 74                                | 26018                             | 22673                        | 16726         | 1.24              | 1.10         |
| С-13           | 0.8         | 0.6        | 66                                | 32367                             | 26973                        | 20859         | 1.38              | 1.21         |
| С-14           | 0.9         | 0.6        | 129                               | 25362                             | 22274                        | 15879         | 2.04              | 1.80         |
| С-15           | 1.0         | 0.7        | 62                                | 16042                             | 15614                        | 11550         | 0.72              | 0.63         |
| С-16           | 0.8         | 0.6        | 204                               | 8076                              | 6281                         | 4666          | 0.95              | 0.84         |
| С-17           | 0.8         | 1.0        | 66                                | 8958                              | 6867                         | 8659          | 0.57              | 0.50         |
| С-18           | 0.8         | 0.4        | 60                                | 6228                              | 4982                         | 2283          | 0.14              | 0.12         |
| Нийт           | <b>14.8</b> | <b>8.4</b> | <b>2706</b>                       | <b>228986</b>                     | <b>213779</b>                | <b>121761</b> | <b>11.36</b>      | <b>10.03</b> |
| Доод давхарга  |             |            |                                   |                                   |                              |               |                   |              |
| С-19           | 0.8         | 0.4        | 150                               | 555                               | 444                          | 222           | 0.03              | 0.02         |
| С-20           | 0.9         | 0.4        | 98                                | 1843                              | 1659                         | 737           | 0.07              | 0.06         |
| Нийт           | <b>0.85</b> | <b>0.6</b> | <b>110</b>                        | <b>2398</b>                       | <b>2103</b>                  | <b>959</b>    | <b>0.10</b>       | <b>0.08</b>  |
| Ордын хэмжээнд | <b>0.8</b>  | <b>0.4</b> | <b>94</b>                         | <b>231384</b>                     | <b>215882</b>                | <b>122720</b> | <b>11.46</b>      | <b>10.11</b> |


МV-007039 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ  
2019 ОНД ГҮЙЦЭТГЭСЭН ГЕОЛОГИ ХАЙГУУЛЫН АЖЛЫН ЗАРДЛЫН НЭГТГЭЛ

Талбайн хэмжээ: 94.21 га

/мянган төгрөгөөр /

| д/д | Ажлын төрөл                        | Хэмжих нэгж | Төлөвлөсөн   |                | нэгжийн өртөг | 2019 он      |                |
|-----|------------------------------------|-------------|--------------|----------------|---------------|--------------|----------------|
|     |                                    |             | Ажлын хэмжээ | Төсөв          |               | Ажлын хэмжээ | Зардал         |
| 1   | Бэлтгэл ажил                       | төг         |              |                |               |              |                |
|     | Төлөвлөгөө зохиох                  | х/ө         | 12           | 744.0          | 62            | 12           | 744.0          |
|     | АСЗ-н тайлал                       |             | 3            | 186.0          | 62            | 3            | 186.0          |
| 2   | Эрлийн маршрут                     | т.км        | 10           | 500.0          | 50            | 5            | 250.0          |
| 3   | Геофизикийн ажил:                  |             |              |                |               |              |                |
| 4   | Уулын ажил:                        |             |              |                |               |              |                |
|     | Суваг малталт                      | куб.м       |              |                |               |              |                |
|     | Шурф нэвтрэлт                      | т.м         | 200          | 10000.0        | 43.33         | 222.7        | 9650.0         |
|     | Булалт                             | куб.м       | 200          | 2000.0         | 8.67          | 222.7        | 1930.0         |
| 5   | Өрөмдлөг:                          |             |              |                |               |              |                |
|     | Баганат                            | т.м         |              |                |               |              |                |
|     | Цохилтот                           | т.м         | 300          | 36000.0        |               |              |                |
| 6   | Сорьцлолт:                         |             |              |                |               |              |                |
|     | геохими                            | сорц        | 10           | 80.0           | 80            | 5            | 400.0          |
|     | технологийн дээж                   | сорьц       | 1            | 200.0          | 200           | 1            | 200.0          |
| 7   | Лабораторийн ажил:                 |             |              |                |               |              |                |
|     | гэрлийн шинжилгээ                  | сорьц       | 5            | 150.0          |               |              |                |
|     | алт жигнэлт, үлээлт                | сорьц       | 300          | 900.0          | 2.04          | 392          | 800.0          |
|     | технологийн туршилт                | сорьц       | 1            | 5000.0         | 8690          | 1            | 8690.0         |
|     | минералогийн                       | сорьц       | 20           | 600.0          |               |              |                |
|     | минерографын                       | сорьц       | 2            | 140.0          |               |              |                |
| 8   | Хүн тээвэр                         | т/км        | 2000         | 1000.0         | 0.5           | 200          | 1000.0         |
|     | Үйлдвэрийн тээвэр                  | т/км        | 6000         | 3000.0         | 0.5           | 6000         | 3000.0         |
| 9   | Топогеодезийн ажил                 | га          | 94           | 5640.0         | 21.23         | 94.21        | 2000.0         |
| 10  | Археологи, палеонтологийн судалгаа | га          | 94.21        | 10000          | 1958.5        | 1            | 1958.5         |
| 11  | Суурин боловсруулалт               | х/ө         | 60           | 20400          | 60            | 340          | 20400.0        |
| 12  | БО-ны.нөх.сэргээлт                 | төг         | 1            | 3000           | 3000          | 1            | 3000.0         |
|     | <b>Зардлын нийт дүн</b>            |             |              | <b>99540.0</b> |               |              | <b>54208.5</b> |
|     | 1га талбайд ноогдох зардал         |             |              | 1056.6         |               |              | 575.4          |

Тусгай зөвшөөрөл эзэмшигч: "Ноён тохой трейд" ХХК



Захирал: *[Signature]* Ц.Ноостой

Геологич: *[Signature]* Ж.Баярсайхан

Санхүүч: *[Signature]* Н.Гэрэлчулуун



АШИГТ МАЛТМАЛ,  
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 06 сарын 21 өдөр

Дугаар 7/91.

Улаанбаатар хот

Техник, эдийн засгийн үндэслэл  
хүлээн авах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн Т/22-05-06 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших "Ноёнтохой трейд" ХХК-ийн MV-007039 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Бор талын алтны шороон ордын өмнөд хэсгийн 8-09 дүгээр шугам хоорондох хэсгийг ил аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн тодотголыг хүлээн авсанд тооцсугай.

2. Хүлээн авсан техник, эдийн засгийн үндэслэлийн үйлдвэрлэлийн нөөцийг бүртгэж, геологийн нөөцөөс хөдөлгөөн хийхийг Уул уурхай, судалгааны хэлтэс (С.Энхболд)-т даалгасугай.

3. Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааг техник, эдийн засгийн үндэслэлийн дагуу явуулах зөвшөөрөл олгох, хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, судалгааны хэлтэс (С.Энхболд)-т даалгасугай.

4. Техник, эдийн засгийн үндэслэлд тусгасан төслийн хүчин чадал, техник, технологид өөрчлөлт орсон, ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд уг техник, эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэхийг Уул уурхай, судалгааны хэлтэс (С.Энхболд)-т даалгасугай.

5. Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших MV-007039 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Бор талын алтны шороон ордын өмнөд хэсгийн 8-09 дүгээр шугам хоорондох хэсгийг ил аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн тодотголыг хуулсан дискийг Уул уурхай, судалгааны хэлтэст тус тус хүлээлгэн өгөхийг "Ноёнтохой трейд" ХХК-д даалгасугай.

ДАРГА

Л.БАЯРМАНДАЛ



5371 727



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ  
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР  
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН  
ДҮГНЭЛТ

2022 оны 05 дугаар сарын 06

№ 7/22-05-06

Улаанбаатар хот

Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших MV-007039 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Бор талын алтны шороон ордын өмнөд хэсгийн 8-09 дүгээр шугам хоорондох хэсгийг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголыг хэлэлцсэн тухай

“Ноёнтохой трейд” ХХК-ийн захиалгаар Уул уурхайн зураг төслийн “Цариг ресурс” ХХК боловсруулсан Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших Бор талын алтны шороон ордын 8-09 дүгээр шугам хоорондох хэсгийг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголд Монгол улсын зөвлөх инженер Л.Жаргалсайхан зөвлөж, Монгол улсын зөвлөх инженер Ч.Дүүжий шинжээчийн дүгнэлт гаргасан байна. Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголыг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Техник-эдийн засгийн үндэслэл хэлэлцэх салбар хуралдаанаар авч хэлэлцэж, дараах ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна.

1. Энэхүү техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол нь ЭБЭХ-ийн сайдын 2012 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 074 дүгээр тушаалаар баталсан “Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник-эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник-эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам”-ын дагуу гүйцэтгэгдсэн байна гэж үзлээ.
2. Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол нь уншихад ойлгомжтой, цэгц дараалал сайтай, мэргэжлийн түвшинд чанартай сайн боловсруулсан, уурхайг эхлэн байгуулж үйлдвэрлэл явуулах бүхий л шат дамжлага буюу үйл ажиллагааг хамарсан, ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах зэрэгт туслах үндсэн баримт бичиг болжээ.
3. Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол нь Төслийн эдийн засгийн гол үзүүлэлтүүд, Ерөнхий мэдээлэл, Ордын геологийн судалгаа, Ил уурхайн үндсэн хэмжээсүүд, үйлдвэрлэлийн нөөц, Олборлолт, Уурхайн угаан баяжуулалтын хэсэг, Хүний нөөц, Дэд бүтэц, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, Байгаль орчин, Төслийн эдийн засаг зэрэг 10 бүлэг, Дүгнэлт, Ашигласан материал бүхий 121 хуудас тайлбар бичиг, 15 хавсралт зургаас бүрдэж байна.
4. Бор талын алтны шороон ордын өмнөд хэсгийн 8-09 дүгээр шугам хоорондох хэсгийн MV-007039 тоот тусгай зөвшөөрлийн талбайн нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хурлын ХХ-15-12 тоот дүгнэлтийг үндэслэн гаргасан УГА-ны даргын 2022 оны 01 дүгээр сарын 25-ны

өдрийн н-05 дугаар тушаалаар дээд давхаргын нөөцийг боломжтой С зэрэглэлээр 121.76 мян.м<sup>3</sup> элсний нөөц, 11.36 кг буюу химийн цэврээр 10.03 кг, Доод давхаргын нөөцийг боломжтой С зэрэглэлээр 959.0 м<sup>3</sup> элсний нөөц, 0.1 кг буюу химийн цэврээр 0.08 кг, нийт боломжтой С зэрэглэлийн 122.72 мян.м<sup>3</sup> элсний нөөц, 11.46 кг буюу химийн цэврээр 10.11 кг алт гэж ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна.

5. Төслийн тодотголд хаягдалгүй олборлох бөгөөд, бохирдол 38.07% буюу 46.73 мян.м<sup>3</sup> байхаар тооцож геологийн боломжтой С зэрэглэлийн нөөцийг магадласан В' үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэн тооцсоноор нийт 169.45 мян.м<sup>3</sup> элс буюу химийн цэврээр 10.11 кг алт олборлохоор төлөвлөжээ. Үйлдвэрлэлийн энэхүү нөөцийг олборлохын тулд 201.56 мян.м<sup>3</sup> хөрс хуулалт хийхээр тооцжээ. Жилд 105.0 мян.м<sup>3</sup> элс олборлох хүчин чадлаар нийт үйлдвэрлэлийн нөөцийг 2 жилийн хугацаанд ашиглахаар төлөвлөсөн байна.

6. Уурхайн ашиглалтын системийн сонголтыг хийхдээ ордын нөөцийн тогтоц болон байршил, хөрсний зузаан, эдийн засгийн үр ашиг зэргийг харгалзан үзэж ил аргаар авто тээвэртэй, гадаад дотоод овоолготой ашиглалтын системээр ашиглах нь оновчтой гэж үзжээ.

7. Ил уурхайд Hyundai robex 300 маркийн экскаватор 1 ширхэг, HOWO ZZ3257 маркийн автосамосвал 2 ширхэг, SDLG953 маркийн утгуурт ачигч 2 ширхэг, Т-170 маркийн бульдозер 1 ширхэг, 80СБ скруббер 1 ширхэг гэсэн үндсэн тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар төлөвлөжээ.

8. Угаан баяжуулах хэсгийн баяжуулах технологийг захиалагч талаас өгсөн техникийн даалгавар болон ШУА, Хими, химийн технологийн хүрээлэнгийн Эрдсийн технологийн лабораторид хийлгэсэн технологи туршилтын тайланд үндэслэн урьдчилсан байдлаар сонгосон байна. Угаан баяжуулах хэсгийн хүчин чадал 105.0 мян.м<sup>3</sup>/жил байна.


9. Шигшүүрийн шинжилгээгээр -2.5+1.18 мм-ийн ангилалд нийт алтны 2.15%, - 1.18+0.6 мм-ийн ангилалд 9.33%, -0.6+0.3 мм-ийн ангилалд 46.92%, -0.3+0.15 мм-ийн ангилалд 34.25%, -0.15+0.0.075 мм-ийн ангилалд 7.35% тус тус ноогдож байна.

10. Ордын элсийг гравитацийн аргаар баяжуулахаар төлөвлөжээ. Үүний үр дүнд 0.08%-ийн гарцтай, 92.5%-ийн металл авалттай баяжмал гарган авч болохыг тогтоосон байна. Анхдагч элсний дундаж агуулгийг 0.07 гр/м<sup>3</sup>-ээр тооцоонд авч ашигласан байна.

11. Бор талын алтны шороон ордын өмнөд хэсгийн 8-09 дүгээр шугам хоорондох хэсгийн уурхайг Төмөр замын Багахангай-Баянгийн хоорондох 6 кВ хүчдэлийн агаарын шугамын №205 тулгуураас салбарлуулан, 6 кВ хүчдэлийн агаарын холболт авч, ТМ-100/6 кВа-ын хүчин чадалтай трансформатораас ЦЭХ-ээр хангаж байгаа бөгөөд цахилгааны зардалд 52.42 сая төгрөг төлөхөөр тооцжээ. Тус уурхайн унд-ахуй болон технологийн усны хэрэгцээг өрөмдөж гаргасан 5 ширхэг гүний худгаас хангахаар тусгасан бөгөөд усны төлбөрт 249.52 сая төгрөг төлөхөөр төлөвлөсөн байна.

12. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлт ба хаалтын зардалд нийт 126.88 сая төгрөг зарцуулахаар тооцоолсон байна. Үүнээс байгаль орчин хамгаалах зардалд 5.5 сая төгрөг, биологийн нөхөн сэргээлтийн зардалд 77.47 сая төгрөг, дүйцүүлэн хамгаалах зардалд 6.0 сая төгрөг, төслийн хаалтын зардалд 31.88 сая төгрөг, хаалтын дараах мониторингийн зардалд 6.04 сая төгрөгийг тус тус зарцуулахаар тусгажээ.

13. Уг төслийг хэрэгжүүлсэнээр 30 хүн ажлын байраар хангагдах ба уурхайн ажилчдын сарын дундаж цалин 1,300.0 мян.төг байхаар байна.



14. Бор талын алтны шороон ордын өмнөд хэсгийн 8-09 дүгээр шугам хоорондох хэсгийг ашиглах ил уурхайн төсөл хэрэгжүүлэхэд нийт 460.60 сая төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай байна. Үүнээс барилга байгууламжийн хөрөнгө оруулалт 160.0 сая төгрөг, машин тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт 253.8 сая төгрөг, тавилга эд хогшилд 6.8 сая төгрөг, дэд бүтцийн хөрөнгө оруулалт 40.0 сая төгрөг байхаар тус тус тооцжээ. Элэгдэл хорогдлын шимтгэлийн зардал ашиглалтын хугацаанд 115.9 сая төгрөг байхаар тооцоолсон байна.

15. Уурхайг ашиглах төслийн хугацаанд нийт 1,477.38 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал гарган, 1,595.67 сая төгрөгийн борлуулалт хийж, 118.3 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллахаар байна. Татвар ногдуулсны дараах байдлаар нийт 103.47 сая төгрөгийн цэвэр ашигтай, 213.57 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын дараах мөнгөн урсгалтай ажиллахаар байна. Улс, орон нутгийн төсөвт 404.49 сая төгрөг төвлөрүүлэхээр тусгажээ. Уурхайн ашиглалтын хугацаанд нэгж бүтээгдэхүүний бүрэн өөрийн өртөг 158,289 төг/гр байна.

16. Төсөл хэрэгжих хугацаанд нийт 213.57 сая төгрөгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал бий болох бөгөөд төслийн өнөөгийн цэвэр үнэ цэнэ (NPV, @8%) 27.28 сая төгрөг, өгөөжийн дотоод норм (IRR) 20%, хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа 1.2 жил байхаар тооцжээ.

Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголын захиалагч, боловсруулагч болон төслийн шинжээчид дараах асуудлыг анхааруулж байна.

1. Төсөл захиалагч нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/205 тоот тушаалаар баталсан Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журмын дагуу үйл ажиллагаа явуулахыг анхааруулж байна.
2. Төсөл хэрэгжүүлэгч нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, дүрэм журмын дагуу ашиглалтын үйл ажиллагааг явуулж, олборлосон алтаа Монгол улсын төв банк Монголбанкинд "Ноёнтохой трейд" ХХК -ийн нэр дээр тушааж байхыг анхааруулж байна.
3. Төсөл захиалагчид Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/181, А/458 тоот тушаалаар батлагдсан Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмын дагуу Хаалтын менежментийн төлөвлөгөөг боловсруулж холбогдох байгууллагаар хэлэлцүүлэн, уурхайн хаалт, нөхөн сэргээлт хийхийг үүрэг болгож байна.
4. Төсөлд шаардлагатай мэргэжлээр Монгол улсын иргэдийг бэлтгэх, тэдгээрийг ажлын байраар хангах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг төсөл хэрэгжүүлэгчид анхааруулж байна.
5. Байгаль орчныг хамгаалах, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудалд онцгой анхаарч холбогдох байгууллагуудтай хамтран ажиллахыг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс даалгаж байна.
6. Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголд тусгагдсан техник, технологийн сонголт, уулын ажлын төлөвлөлт, цахилгаан хангамж, дэд бүтцийн сонголт, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шийдлийн талаар төслийн эдийн засгийн үндэслэлийн тодотголыг боловсруулсан Уул уурхайн зураг төслийн "Цариг ресурс" ХХК, мөн ТЭЗҮ-ийн тодотголын үнэн бодит байдал, чанарт дүгнэлт гаргасан шинжээч Монгол Улсын зөвлөх инженер Ч.Дүүжий тус тус хариуцна.

Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголд хийсэн шинжээчийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Салбар хуралдаанаас Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4, 48 дугаар зүйлийн 48.4, Газрын хэвлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгүүд болон энэ дүгнэлт, холбогдох хуулийн заалтуудыг тус тус үндэслэн дараах шийдвэр гаргахыг Ашигт малтмал, газрын тосны газрын даргад уламжлахаар тогтов. Үүнд:

1. "Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших MV-007039 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Бор талын алтны шороон ордын өмнөд хэсгийн 8-09 дүгээр шугам хоорондох хэсгийг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол"-ыг хүлээн авах;
2. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан уурхайн хүчин чадал, техник тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлд нэмэлт тодотгол хийлгэж ЭБМЗ-ийн салбар хуралдаанаар хэлэлцүүлж байхыг төсөл хэрэгжүүлэгчид анхааруулах;
3. Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших MV-007039 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Бор талын алтны шороон ордын өмнөд хэсгийн 8-09 дүгээр шугам хоорондох хэсгийг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол, түүнийг хуулсан диск, ЭБМЗ-ийн дүгнэлтийн хамт Геологийн баримтын төв архивд холбогдох шаардлагад нийцүүлэн хүлээлгэн өгөх арга хэмжээг авах.

ТАНИЛЦСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.ЭЛБЭГЗАЯА

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:


ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН  
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Ч.ЦОГТБААТАР

БОЛОВСРУУЛСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН  
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ХУРАЛДААНЫ  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Э.МӨНХЗОРИГ





**"Ноён тохой трейд" ХХК-ийн Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших MV-007039 тоот ашигла  
8-09 дүгээр шугам хоорондох хэсгийг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үн**

| Блоктын дугаар        | Геологийн нөөц          |                    |                  |                        |                          |                             |                          | Ашиглалтын нөөц                 |                         |                    |                   |                        |                          |
|-----------------------|-------------------------|--------------------|------------------|------------------------|--------------------------|-----------------------------|--------------------------|---------------------------------|-------------------------|--------------------|-------------------|------------------------|--------------------------|
|                       | Блоктын талбай /мян.м2/ | Хөрсний зузаан /м/ | Элсний зузаан/м/ | Хөрс эзлэхүүн /мян.м3/ | Элсний эзлэхүүн /мян.м3/ | Дундаж агуулга /шлик/ гр/м3 | Металлын нөөц /Шлик/ кг/ | Металлын нөөц /химик цэвэр/ кг/ | Блоктын талбай /мян.м2/ | Хөрсний зузаан /м/ | Элсний зузаан /м/ | Хөрс эзлэхүүн /мян.м3/ | Элсний эзлэхүүн /мян.м3/ |
| <b>Дээд давхарга</b>  |                         |                    |                  |                        |                          |                             |                          |                                 |                         |                    |                   |                        |                          |
| С-1                   | 2.89                    | 0.80               | 0.40             | 2.31                   | 1.15                     | 0.100                       | 0.12                     | 0.10                            | 2.89                    | 0.80               | 0.40              | 2.31                   | 1.15                     |
| С-2                   | 6.23                    | 0.60               | 0.30             | 3.91                   | 2.14                     | 0.095                       | 0.20                     | 0.18                            | 6.23                    | 0.60               | 0.30              | 3.91                   | 2.14                     |
| С-3                   | 6.59                    | 0.80               | 0.30             | 4.94                   | 1.65                     | 0.136                       | 0.22                     | 0.20                            | 6.59                    | 0.80               | 0.30              | 4.94                   | 1.65                     |
| С-4                   | 21.11                   | 1.10               | 0.40             | 23.93                  | 8.44                     | 0.130                       | 1.09                     | 0.96                            | 21.11                   | 1.10               | 0.40              | 23.93                  | 8.44                     |
| С-5                   | 30.77                   | 1.10               | 0.40             | 34.87                  | 13.54                    | 0.103                       | 1.39                     | 1.23                            | 30.77                   | 1.10               | 0.40              | 34.87                  | 13.54                    |
| С-6                   | 3.47                    | 1.10               | 0.20             | 3.71                   | 0.70                     | 0.091                       | 0.06                     | 0.06                            | 3.47                    | 1.10               | 0.20              | 3.71                   | 0.70                     |
| С-7                   | 12.91                   | 1.20               | 0.50             | 15.13                  | 6.64                     | 0.093                       | 0.61                     | 0.54                            | 12.91                   | 1.20               | 0.50              | 15.13                  | 6.64                     |
| С-8                   | 1.35                    | 0.40               | 0.60             | 0.54                   | 0.81                     | 0.240                       | 0.19                     | 0.17                            | 1.35                    | 0.40               | 0.60              | 0.54                   | 0.81                     |
| С-9                   | 3.50                    | 0.60               | 0.20             | 2.10                   | 0.70                     | 0.113                       | 0.08                     | 0.07                            | 3.50                    | 0.60               | 0.20              | 2.10                   | 0.70                     |
| С-10                  | 1.52                    | 0.20               | 0.20             | 0.30                   | 0.30                     | 0.155                       | 0.05                     | 0.04                            | 1.52                    | 0.20               | 0.20              | 0.30                   | 0.30                     |
| С-11                  | 15.60                   | 1.10               | 0.30             | 16.38                  | 5.07                     | 0.062                       | 0.31                     | 0.28                            | 15.60                   | 1.10               | 0.30              | 16.38                  | 5.07                     |
| С-12                  | 26.02                   | 0.90               | 0.60             | 22.67                  | 16.73                    | 0.074                       | 1.24                     | 1.10                            | 26.02                   | 0.90               | 0.60              | 22.67                  | 16.73                    |
| С-13                  | 32.37                   | 0.80               | 0.60             | 26.97                  | 20.86                    | 0.066                       | 1.38                     | 1.21                            | 32.37                   | 0.80               | 0.60              | 26.97                  | 20.86                    |
| С-14                  | 25.36                   | 0.90               | 0.60             | 22.27                  | 15.88                    | 0.129                       | 2.04                     | 1.80                            | 25.36                   | 0.90               | 0.60              | 22.27                  | 15.88                    |
| С-15                  | 16.04                   | 1.00               | 0.70             | 15.61                  | 11.55                    | 0.062                       | 0.72                     | 0.63                            | 16.04                   | 1.00               | 0.70              | 15.61                  | 11.55                    |
| С-16                  | 8.08                    | 0.80               | 0.60             | 6.28                   | 4.67                     | 0.204                       | 0.95                     | 0.84                            | 8.08                    | 0.80               | 0.60              | 6.28                   | 4.67                     |
| С-17                  | 8.96                    | 0.80               | 1.00             | 6.87                   | 8.66                     | 0.066                       | 0.57                     | 0.50                            | 8.96                    | 0.80               | 1.00              | 6.87                   | 8.66                     |
| С-18                  | 6.23                    | 0.80               | 0.40             | 4.98                   | 2.28                     | 0.060                       | 0.14                     | 0.12                            | 6.23                    | 0.80               | 0.40              | 4.98                   | 2.28                     |
| Нийт С                | 228.99                  | 0.85               | 0.60             | 213.78                 | 121.76                   | 0.093                       | 11.36                    | 10.03                           | 228.99                  | 0.85               | 0.60              | 213.78                 | 121.76                   |
| <b>Доод давхарга</b>  |                         |                    |                  |                        |                          |                             |                          |                                 |                         |                    |                   |                        |                          |
| С-19                  | 0.56                    | 0.80               | 0.40             | 0.44                   | 0.22                     | 0.150                       | 0.03                     | 0.020                           | 0.56                    | 0.80               | 0.40              | 0.44                   | 0.22                     |
| С-20                  | 1.84                    | 0.90               | 0.40             | 1.66                   | 0.74                     | 0.098                       | 0.07                     | 0.060                           | 1.84                    | 0.90               | 0.40              | 1.66                   | 0.74                     |
| Нийт С                | 2.40                    | 0.85               | 0.60             | 2.10                   | 0.96                     | 0.110                       | 0.10                     | 0.08                            | 2.40                    | 0.85               | 0.60              | 2.10                   | 0.96                     |
| Ордын хэмжээнд нийт С | 231.38                  | 0.80               | 0.40             | 215.88                 | 122.72                   | 0.094                       | 11.46                    | 10.11                           | 231.38                  | 0.80               | 0.40              | 215.88                 | 122.72                   |

2021 оны 12 дугаар сарын 22 ны өдрийн ХХ-15-12 тоот ЭБМЗ-ийн дүгнэлт, 2022 оны 01-р сарь ордод хамаарч байгаа ба хайгуулын ажлаар тогтоогдсон Геологийн боломжтой (С) нөөцөд тулгуурлан орших бохирдол тооцсон эдийн засгийн хувьд үр ашигтай үйлдвэрлэлийн нөөцийг уул уурхайн сайд зэрэглэлийн нөөцийг магадласан (В') үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэв. Ордын нийт магадласан В' /Шлихээр 11.46 кг/.

Бор талын шороон ордын өмнөд хэсгийн 8-09 дүгээр шугам хоорондох хэсгийн алтны шороон о хөрсөнд 0.1 м зузаан үе үлдээх, ул чулуулгаас мөн 0.1 м зузаан үеийг элстэй цуг олборлолтонд хамру; үеүд бохирдуулагч чулуулаг болно. Иймээс ордыг ашиглалтын үед хаягдалгүй олборлоно.

Үзүүлэлт гаргасан:

"Цариг Ресурс" ХХК-ийн

Уулын инженер: ..... / А.Эрдэнэбулган/



ЭБМЗ-ийн 112-05-06 дүгээр дүгнэлтийн хавсралт

039 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай дахь Бор талын шороон ордын өмнөд хэсгийн эдийн засгийн үндэслэлийн тодотголын үйлдвэрлэлийн нөөцийн нэгдсэн хүснэгт

| Ашиглалтын нөөц        |                          |                             |                           |                                 | Бохирдолт        |                                |                | Үйлдвэрлэлийн нөөц             |                        |                          |                             |                           |                                 |
|------------------------|--------------------------|-----------------------------|---------------------------|---------------------------------|------------------|--------------------------------|----------------|--------------------------------|------------------------|--------------------------|-----------------------------|---------------------------|---------------------------------|
| Хөрс эзлэхүүн /мян.мЗ/ | Элсний эзлэхүүн /мян.мЗ/ | Дундаж агуулга /шлих/ гр/мЗ | Металлын нөөц /Шлих/ /кг/ | Металлын нөөц /хими цэвэр/ /кг/ | Бохирдолтын хувь | Бохирдуулагч чулуулаг /мян.мЗ/ | Блокний дугаар | Бортоор нэмэгдэх хөрс /мян.мЗ/ | Хөрс эзлэхүүн /мян.мЗ/ | Элсний эзлэхүүн /мян.мЗ/ | Дундаж агуулга /шлих/ гр/мЗ | Металлын нөөц /Шлих/ /кг/ | Металлын нөөц /хими цэвэр/ /кг/ |
| 2.31                   | 1.15                     | 0.100                       | 0.12                      | 0.10                            | 50.67            | 0.58                           | В'             | 0.14                           | 2.16                   | 1.74                     | 0.066                       | 0.12                      | 0.10                            |
| 3.91                   | 2.14                     | 0.095                       | 0.20                      | 0.18                            | 58.71            | 1.25                           | В'             | 0.11                           | 3.40                   | 3.39                     | 0.060                       | 0.20                      | 0.18                            |
| 4.94                   | 1.65                     | 0.136                       | 0.22                      | 0.20                            | 80.80            | 1.33                           | В'             | 0.37                           | 4.66                   | 2.98                     | 0.075                       | 0.22                      | 0.20                            |
| 23.93                  | 8.44                     | 0.130                       | 1.09                      | 0.96                            | 50.33            | 4.25                           | В'             | 1.06                           | 22.88                  | 12.69                    | 0.086                       | 1.09                      | 0.96                            |
| 34.87                  | 13.54                    | 0.103                       | 1.39                      | 1.23                            | 45.70            | 6.19                           | В'             | 1.30                           | 33.09                  | 19.72                    | 0.071                       | 1.39                      | 1.23                            |
